# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 28 (313)

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:**

- *Ардын болон гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнасан тухай*

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:**

- *"Мянганы зам" авто замын санхүүжилтийн тухай*
- *Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2003 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2003 оны долдугаар сарын 31 № 28 (313)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 429. | Томас Вильхелмийг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 104 | 714 |
| 430. | Бүгд Найрамдах Австри Улсын зарим иргэнийг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 106 | 714 |
| 431. | ОХУ-ын зарим иргэнийг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 107 | 714 |
| 432. | "Хилчний алдар" медаль бий болгох тухай | Дугаар 108 | 714 |
| 433. | Гомбын Миезгомбод Монгол Улсын Ардын багш цол хүртээх тухай | Дугаар 109 | 715 |
| 434. | Думаагийн Содномд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 110 | 715 |
| 435. | Навааны Бадрахад Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай | Дугаар 111 | 716 |
| 436. | Лувсангончигийн Гоогормаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 112 | 716 |
| 437. | Цэнд-Аюушийн Норовпилд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 113 | 716 |
| 438. | Магваны Батмөнхөд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 114 | 716 |
| 439. | Бумбын Жугдэрнамжилд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 115 | 717 |
| 440. | Төмөрбаатарын Цэцгээд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 116 | 717 |
| 441. | Лувсандоогийн Балдандоржид Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай | Дугаар 117 | 717 |
| 442. | Жамъянгийн Төмөрмунад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 118 | 717 |
| 443. | Хэнтий аймгийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 119 | 718 |
| 444. | Наваанцэрэнгийн Мажигсүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 120 | 720 |
| 445. | Сүрэнжавын Дорждамбад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 121 | 720 |
| 446. | Довдонгийн Сэмхээд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 122 | 721 |
| 447. | Төв аймгийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 123 | 721 |
| 448. | Ишжамцын Жанцандоржид Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай | Дугаар 124 | 724 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 449. | Хөтөлбөр батлах тухай | Дугаар 121 | 724 |
| 450. | "Мянганы зам" авто замын санхүүжилтийн тухай | Дугаар 123 | 728 |
| 451. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 124 | 728 |

| | | | |
|---|---|---|---|
| 452. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 126 | 730 |
| 453. | Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай | Дугаар 127 | 730 |



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 6 дугаар сарын 24-ний өдөр** | **Дугаар 104** | **Улаанбаатар хот**

### Томас Вильхелмийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, АНУ-ын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж АНУ-аас тус улсад суугаа Элчин сайдын яамны дэргэдэх Батлан хамгаалахын атташе, хурандаа Томас Вильхелмийг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 106** | **Улаанбаатар хот**

### Бүгд Найрамдал Австри Улсын зарим иргэнийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улсын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны гадаад хэргийн яамны газрын захирал Валентин Инцко, Монгол Улсын Өргөмжит консул Иоханнес Штийдл нарыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 107** | **Улаанбаатар хот**

### ОХУ-ын зарим иргэнийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын иргэн, дор дурдсан хүмүүсийг "найрамдал" медалиар шагнасугай.

1. Алла Георгиевна Грязнова -ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Санхүүгийн академийн ректор
2. Николай Алексеевич Лугинов -ОХУ-ын Зохиолчдын холбооны удирдах газрын нарийн бичгийн дарга, П.А.Ойунскийн нэрэмжит утга зохиолын музейн захирал
3. Леонид Михайлович Рошаль -ОХУ-ын Анагаах ухааны академийн хүүхдийн эрүүл мэндийн төвийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн тасгийн эрхлэгч

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 108** | **Улаанбаатар хот**

### "Хилчний алдар" медаль бий болгох тухай

ЗАРЛИГ болгох нь:

1. Улсын хил хамгаалах байгууллагад алба хааж, тасралтгүй олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа генерал, офицер, улирсан албан хаагчдыг шагнах "Хилчний алдар" медаль бий болгосугай.

2. "Хилчний алдар" медалийн тодорхойлолт, шагнах журмыг нэгдүгээр, загварыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Дээр дурдсан медалиар шагнаж байх эрхийг хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 108 тоот зарлигийн нэгдүгээр хавсралт*

## НЭГ. "ХИЛЧНИЙ АЛДАР" МЕДАЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

"Хилчний алдар" медаль нь /цаашид "медаль" гэх/ нь дөрвөн зуг тэмүүлсэн гэрлийн цацраг дээр улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахыг бэлэгдсэн найман зовхист хандсан нуман хээ бүхий дугуй бамбай хэлбэртэй байна. Бамбайн голд монгол төрийн уламжлалт бэлэгдэл соёмбыг байрлуулна.

Медаль гурван зэрэгтэй байх ба голдоо зэргийг заасан шар өнгийн босоо зураас бүхий зүүлттэй, ар талд нь "Хилчний алдар" гэсэн бичээстэй байна.

Медалийн зүүлтийн дээд тал эвэр угалзан, доод хэсэг нуман хүрээтэй байна.

Медалийг зүүлттэй алтан шар өнгийн гархиар холбоно. Зүүлтийн ард талд хувцаст тогтоох зүүтэй байна.

Медалийн гэрлийн цацрагийг цагаан өнгийн никель, бамбай, зүүлтийг ногоон, соёмбо, нуман хээ, бамбай, зүүлтний хүрээг алтан шар өнгийн металлаар үйлдэнэ.

Медалийн лентийг шар зураастай, ногоон өнгийн торгомсог эдээр хийнэ.

## ХОЁР. "ХИЛЧНИЙ АЛДАР" МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

1. Хил хамгаалах байгууллагад дор дурдсан хугацаагаар цэргийн алба хааж, үр бүтээлтэй ажиллаж байгаа генарал, офицер, цэргийн улирсан албан хаагчдыг "Хилчний алдар" 1, 2, 3 дугаар зэргийн медалиар шагнана.

1.1. Улсын хил хамгаалах байгууулагад 10-аас доошгүй жил алба хаасан тохиолдолд "Хилчний алдар" 3 дугаар зэргийн медалиар;

1.2. Улсын хил хамгаалах байгууулагад 15-аас доошгүй жил алба хаасан тохиолдолд "Хилчний алдар" 2 дугаар зэргийн медалиар;

1.3. Улсын хил хамгаалах байгууллагад 20-иос доошгүй жил алба хаасан тохиолдолд "Хилчний алдар" 1 дүгээр зэргийн медалиар;

2. Уг медалиудаар зэргийн дараалпыг баримтлан шагнана. Хоёр шагналын хооронд 5-аас доошгүй жилийн хугацаатай байна.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 6 дугаар сарын 25–ны өдөр** | **Дугаар 109** | **Улаанбаатар хот**

**Гомбын Миеэгомбод Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай**

Боловсролын байгууллагад олон жил санаачлага, үр бүтээлтэй ажиллаж үндэсний дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх, залуу үеийг сурган хүмүүжүүлэх, эдийн засгийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, их, дээд сургуулиудын удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн зөвлөх багш Гомбын Миеэгомбод Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2003 оны 6 дугаар сарын 25–ны өдөр** | **Дугаар 110** | **Улаанбаатар хот**

**Думаагийн Содномд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай**

Монгол Улсын санхүү, эдийн засгийн төв байгууллагуудыг удирдаж, улмаар Засгийн газрыг тэргүүлэн олон жил санаачилга үр бүтээлтэй ажиллаж санхүү, эдийн засгийн албыг хөгжүүлэн бэхжүүлэх, гадаад харилцааг өргөтгөх, улсынхаа хөгжил, дэвшил, ард түмний аж байдлыг дээшлүүлэхэд оруулж ирсэн хувь нэмрийг нь үнэлж "Монгол алт" ХК-ийн эдийн засгийн зөвлөх Думаагийн Содномд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 2003 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 119 | Улаанбаатар хот |

**Хэнтий аймгийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Хэнтий аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, төр захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг тус аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан одон, медалиар шагнасугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Балаагийн Даваадорж -Хэнтий аймгийн Засаг даргын орлогч

### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Доржийн Дашням -Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
2. Маналын Доржлалам -Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл
3. Сэрчинжавын Дугаржав -"Монголросцветмет" нэгдлийн харьяа Хэнтий аймгийн Дархан сумын Бор-Өндөр хот дахь уулын баяжуулах үйлдвэрийн засварчин
4. Дондогийн Жавзмаа -Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын дотрын их эмч
5. Содовын Жамъяншадав -Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг дарга
6. Жамсрангийн Зэнэмэдэр -Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр дунд сургуулийн математикийн багш
7. Лхамсүрэнгийн Ичинхорлоо -Хэтий аймгийн Дархан сумын Бор-Өндөр хотын "Бор-Өндөр" цогцолбор дунд сургуулийн биеийн тамирын багш
8. Дашдоржийн Нармандах -Хэнтий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дэд захирал
9. Дэмбэрэлийн Насанжаргал -Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч
10. Лувсаншаравын Отгон -Хэнтий аймгийн Дархан сумын Бор-Өндөр хотын "Бор-Өндөр" цогцолбор дунд сургуулийн байгалийн шинжлэлийн багш
11. Тараажавын Оюунтуяа -Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн багш
12. Содномын Рэгзэд -Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны нягтлан бодогч
13. Дашийн Чимэддорж --Хэнтий аймгийн Ахмадын хорооны дарга

### ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

Соронзонгийн Эрдэнэ -Хэтий аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн хошууч

### ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Эмээлийн Баатарчулуун -Хэтий аймгийн Баянмөнх сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч, их эмч
2. Зундуйн Баатаржав -"Монголросцветмет" нэгдлийн харьяа Хэнтий аймгийн Дархан сумын Бор-Өндөр хот дахь уулын баяжуулах үйлдвэрийн жолооч
3. Дамбийн Базарваань -"Монгол даатгал" ХХК-ийн Хэнтий аймаг дахь салбарын мэргэжилтэн
4. Содовын Банзрагч -Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Гичгэнэ багийн Засаг дарга
5. Данзанжамцын Батмөнх -Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын нийтлэг үйлчилгээний газрын дарга
6. Шагдарын Бухаа -Хэнтий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн инженер багш
7. Гомбын Бямбасүрэн -Хэнтий аймгийн Баянмөнх сумын цэцэрлэгийн эрхлэгч
8. Цэгмидийн Валясүрэн -Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн
9. Наваандонойн Ганболд -Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Өндөрхаан хотын захирагч

| | |
|---|---|
| 10. Доржийн Гомбо-Очир | -Хэнтий аймгийн Батширээт сумын дунд сургуулийн дуу хөгжмийн багш |
| 11. Бадарчийн Даваажав | -Хэнтий аймгийн ардын дуу бүжгийн "Хан Хэнтий" чуулгын хөгжимчин |
| 12. Бэгзийн Даваажав | -Хэнтий аймгийн ардын дуу бүжгийн "Хан Хэнтий" чуулгын дуучин |
| 13. Дондогийн Дадиймаа | -Хэнтий аймгийн Батноров сумын дунд сургуулийн бага ангийн багш |
| 14. Жамбалын Дашдондог | -Хэнтий аймгийн Холбооны газрын Баянмөнх сумын салбарын эрхлэгч |
| 15. Лувсанжамцын Дорждулам | --Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн лаборант |
| 16. Гэндэнжамцын Доржпагам | -Хэнтий аймгийн Холбооны газрын залгагч |
| 17. Нааваны Доржханд | -Хэнтий аймгийн Дадал сумын дунд сургуулийн бага ангийн багш |
| 18. Цэндийн Дугар | -Хэнтий аймгийн ардын дуу бүжгийн "Хан Хэнтий" чуулгын хөгжимчин |
| 19. Гомбын Дулмаа | -Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Хан Хэнтий" цогцолбор дунд сургуулийн сургалтын албаны дарга |
| 20. Доржоогийн Жамбаа | -Хэнтий аймгийн Батноров сумын Засаг дарга |
| 21. Гомбожавын Ичинхорлоо | -Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт тосгоны дунд сургуулийн математикийн багш |
| 22. Ламзавын Ичинхорлоо | -Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх баригч бага эмч |
| 23. Хоохойн Лхагвахорол | -Хэнтий аймгийн ардын дуу бүжгийн "Хан Хэнтий" чуулгын дуучин |
| 24. Ойдвын Лхамсүндэв | -Хэнтий аймгийн Баян-Адрага сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга |
| 25. Ишийн Маахүү | -Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн ахлах статистикч |
| 26. Жанчивын Маруся | -Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн сувилагч |
| 27. Сэндэмийн Мөнхжаргал | -Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч |
| 28. Жунайн Ням | -Хэнтий аймгийн Галшар сумын хүн эмнэлгийн эх баригч бага эмч |
| 29. Дамбийнямын Намсрай | -Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын жолооч |
| 30. Доржийн Намсрай | -Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг дарга |
| 31. Гонсжавын Наранхүү | -Хэнтий аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын дарга |
| 32. Лувсаншаравын Наташа | -Хэнтий аймгийн Дархан сумын Бор-Өндөр хотын "Бор-Өндөр" цогцолбор дунд сургуулийн орос хэлний багш |
| 33. Санжидын Нина | -Хэнтий аймгийн Баян-Адрага сумын хүн эмнэлгийн салбарын эх баригч бага эмч |
| 34. Батсүхийн Нэргүй | -"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн харьяа Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын автокранч |
| 35. Галсанжамцын Норовсүрэн | -"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн харьяа Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын монтёрч |
| 36. Равжирын Ойдовсүрэн | -"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн харьяа Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын техникч |
| 37. Жамбалсүрэнгийн Оюун | -Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн эрхлэгч |
| 38. Лувсанжамцын Оюунбилэг | -Хэнтий аймгийн ардын дуу бүжгийн "Хан Хэнтий" чуулгын бүжигчин |
| 39. Сэдэдийн Оюунгэрэл | -Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын дунд сургуулийн газар зүйн багш |
| 40. Наваанрэнчингийн Оюунчимэг | -Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын Тамгын газрын дарга |
| 41. Санжаажавын Пүрэвжав | -Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын дунд сургуулийн бага ангийн багш |
| 42. Жамбалсүрэнгийн Сүхбаатар | -Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Хан Хэнтий" цогцолбор дунд сургуулийн захирал |
| 43. Сийзийн Төмөрбаатар | -Хэнтий аймгийн Хэрлэн сумын нийтийн аж ахуй, үйлчилгээний "Хэнтий-Ус" ХХК-ийн зуухны машинч |
| 44. Жамбалпэрэнлэйн Уртнасан | -Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч |

13. Доржийн Дамбадагва -Төв аймгийн Зуунмод сум дахь, барилга засварын "Төв-АЗЗА" ХХК-ийн ерөнхий инженер

14. Долцонгийн Дондог -Монгол Улсын Их Хурлын гишүүн

15. Сандагийн Дуламсүрэн -Төв аймгийнЗасаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга

16. Дагвадоржийн Жамбалдорж -Төв аймгийн Прокурорын орлогч

17. Таяагийн Лхагвацэрэн -Төв аймгийн Сэргэлэн сумын дунд сургуулийн физик, математикийн багш

18. Чойжилын Мөнх-Очир -Төв аймгийн Алтанбулаг сумын малчин

19. Дамдинсүрэнгийн Оргодол -Төв аймгийн Биеийн тамир, спорт хорооны дарга

20. Дашнямын Отгонсүрэн -Төв аймгийн Лүн сумын Хүн эмнэлгийн дотрын их эмч

21. Жалбуугийн Пунцагдулам -Төв аймгийн Борнуур сумын Хүн эмнэлгийн эх баригч бага эмч

22. Шагдарын Пүрэвжав -Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн нүдний их эмч

23. Насанбаярын Халзанхүү -МАХН-ын Төв аймгийн хорооны улс төрийн ажилтан

24. Сандагдоржийн Хүрэлтогоч -Төв аймгийн Эрдэнэсант сумын Хүн эмнэлгийн эрхлэгч, их эмч

25. Наваань Цэдэв -Төв аймгийн Зуунмод сумын "Оддын гэгээ" хоршооны эзэн

26. Түвдэнгийн Цэдэндаш -Төв аймгийн Зуунмод сумын "Хүмүүн" цогцолбор дунд сургуулийн математикийн багш

27. Дэмбэрэлийн Цэрмаа -Төв аймгийн Баянхангай сумын дунд сургуулийн биологийн багш

28. Пүрэвдоржийн Цэрэн -Төв аймгийн засаг даргын орлогч

29. Баярын Цэрэндолгор -Төв аймгийн Холбооны газрын залгагч

30. Гомбын Чогдонхорлоо -Төв аймгийн Зуунмод сумын "Хүмүүн" цогцолбор дунд сургуулийн дэд захирал

31. Түвшингийн Янжмаа -Төв аймгийн Зуунмод сумын 5 дугаар дунд сургуулийн хими, биологийн багш

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Цогбадрахын Александр -Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Цэрэг, иргэний хамгаалалтын штабын офицер, дэд хурандаа

2. Сосорын Цэнд-Аюуш -Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Нямсүрэнгийн Агваан -Төв аймгийн Зуунмод сумын "Төв-Ус" ХК-ийн жолооч

2. Нямын Адъяабазар -МУЭ-ийн хорооны Төв аймгийн Зуунмод сум дахь чөлөөт уранбүтээлч, зураач

3. Лувсандашийн Баасандамба -Төв аймгийн Эрдэнэ сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш

4. Дэмбэрэлийн Баатархүү -Төв аймгийн Сэргэлэн сумын дунд сургуулийн математикийн багш

5. Шадийн Батаа -Төв аймгийн Сэргэлэн сумын 1 дүгээр багийн Засаг дарга

6. Хайшаанчгүйн Батболд -Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын дарга

7. Гомбын Батмөнх -Төв аймгийн Цээл сумын дунд сургуулийн зохион бүтээх хөдөлмөрийн багш

8. Галтын Бат-Эрдэнэ -Төв аймгийн Жаргалант сумын Засаг дарга

9. Дамдингийн Гантөмөр -Төв аймгийн Баянчандмань сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

10. Мирагийн Гантулга -Төв аймгийн Дулааны эрчим хүчний газрын механикч

11. Дарьжавын Готов -Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын уурын зуухны механикч

12. Жамбалдоржийн Даваадорж -Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг дарга

13. Балдангийн -Төв аймгийн Баянчандмань

Даваасүрэн сумын Замт багийн Засаг дарга

14. Өлзийн Дашзэвэг -Төв аймгийн Баянжаргалан сумын Ахмадын хорооны дарга

15. Нямсүрэнгийн Дашцэрэн -Төв аймгийн Зуунмод сумын "Төв-Ус" ХК-ийн гагнуурчин

16. Жүрмэдийн Долгор -Төв аймгийн Баян сумын дунд сургуулийн дэд захирал

17. Зулаагын Доржгочоо -Төв аймгийн Зуунмод сумын 4 дүгээр дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

18. Сэдэдийн Дулам -Төв аймгийн Мөнгөнморьт сумын засаг дарга

19.Данзандаржаагийн Дэлгэрсайхан -"Өлзийт төв" ХХК-ийн харьяа -Төв аймгийн Зуунмод сум дахь "Өлзийт" оёдлын үйлдвэрийн эсгүүрийн мастер

20. Жаахүүгийн Дэмчигсүрэн --Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг дарга

21. Дашбалдангийн Жагаа -Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

22. Хадын Лхагвасүрэн -Төв аймгийн Бүрэн сумын дунд сургуулийн арга зүйч багш

23. Сэрээтэрийн Лхүндэврэгзэн -Төв аймгийн Эрдэнэсант сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан

24. Содовын Мядаг -Төв аймгийн Заамар сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн хичээлийн эрхлэгч

25. Гомбын Намнанхүү -Төв аймгийн Дулааны эрчим хүчний газрын халаалтын зуухны механикч

26. Дамдингийн Нас-Урт -Төв аймгийн Баяндэлгэр сумын цэцэрлэгийн эрхлэгч

27. Цэдэндамбын Норовсүрэн -Төв аймгийн Өндөрширээт сумын 2 дугаар багийн Засаг дарга

28. Чулууны Пүрэвжал -Төв аймгийн Архуст сумын "Архуст-Шунхлай" ХК-ийн малчин

29. Чойжилын Раданбэгзэд -Төв аймгийн Дэлгэрхаан сумын малчин

30. Жигжидийн Раднаадаргиа -Төв аймгийн Баян сумын дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

31. Сосорбурамын Өлзийхишиг -Төв аймгийн Аргалант сумын Хүн эмнэлгийн эх баригч бага эмч

32. Балжиннямын Саранцогт -"Өлзийт төв" ХХК-ийн харьяа Төв аймгийн Зуунмод сум дахь "Өлзийт" оёдлын үйлдвэрийн цехийн мастер

33. Дугардоржийн Сэлэнгэбаатар -Төв аймгийн Сүмбэр сумын "КДП" хоршооны эзэн

34. Содномын Тунгалаг -Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

35. Уламбаярын Туяа -Төв аймгийн Сүмбэр сумын Засаг дарга

36.Намсрайн Түвшинжаргал -Төв аймгийн Шүүхийн шүүгч

37. Батсүхийн Хишгээ -Төв аймгийн Угтаалцайдам сумын Хүн эмнэлгийн эх баригч бага эмч

38. Далрайн Хумбанцагаан -Төв аймгийн Баянцогт сумын дунд сургуулийн газар зүйн багш

39. Дүвжирийн Цагаан -Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын уурын зуухны механикч

40. Бадарчийн Цэнд-Аюуш -Төв аймгийн Эрдэнэ сумын дунд сургуулийн бага ангийн багш

41. Даваагийн Цэрэн -Төв аймгийн Зуунмод сумын "Солонго салон" үсчний газрын үсчин

42. Далхжавын Цэрэннадмид -Төв аймгийн Баянжаргалан сумын соёлын төвийн эрхэгч

43. Галбадрахын Шагдар -Төв аймгийн Баянжаргалан сумын Улаан-Ухаа багийн Засаг дарга

44.Содномцэрэнгийн Ядамсүрэн -Төв аймгийн Баянчандмань сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1.Бадамсүрэнгийн Болд -Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын замын ахлах байцаагч, цагдаагийн хошууч

2. Гомбын Сосорбарам -Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн байцаагч, цагдаагийн ахмад

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 6 дугаар сарын 25–ны өдөр | Дугаар 124 | Улаанбаатар хот

**Ишжамцын Жанцандоржид Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай**

Мал сүргээ олон жил тогтвортой өсгөн үржүүлж, үүлдэр угсааг нь сайжруулан ашиг шимийг нь сайн ашиглаж, иргэдийг малжуулахад идэвх санаачлага гарган, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Эрдэнэ-Уул багийн малчин Ишжамцын Жанцандоржид Монгол Улсын гавьяат малчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 21–ний өдөр | Дугаар 121 | Улаанбаатар хот

**Хөтөлбөр батлах тухай**

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж мөрдөхийг Байгаль орчны сайд У.Барсболдод даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

*Засгийн газрын 2003 оны 121 дүгээр тогтоолын хавсралт*

## МОНГОЛ ОРНЫ ИДЛЭГ ШОНХОРЫГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийд тархсан 28 зүйл шонхортны овгоос 10 зүйл нь Монгол оронд бүртгэгдсэний дотор биеэр том, анд хэрэглэгддэг нь идлэг шонхор юм. Энэ зүйл нь манай орны ойт хээр, хээр тал, говь, заримдаг цөлийн баянбүрд, хад цохиотой орчноор өргөн тархсан бөгөөд хаврын улиралд 6,0 мянга орчим, намрын улиралд 11,5-16,5 мянган толгой идлэг шонхорын нөөцтэй байдгийг судалгаагаар тогтоосон байна. Идэш тэжээлийн хүрэлцээ, амьдрах орчны нөхцөлөөс хамааран идлэг шонхорын тархац, тоо толгой байнга өөрчлөгдөж байдаг ажээ. Хэдийгээр манай оронд идлэг шонхорын нэлээд нөөц байгаа ч гэсэн уг амьтныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн үржих орчин бүрдээгүйн улмаас тэдгээрийн өсөлт, тоо толгойд сөрөг нөлөөлсөөр байна.

"Амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах конвенци"-ийн гишүүн орны хувьд Монгол Улс уг конвенцийн 2 дугаар хавсралтад орсон идлэг шонхорыг хамгаалах асуудлыг төрийн бодлогын хэмжээнд авч үзэж, түүний идэш тэжээл, нөхөн үржих таатай орчинг бүрдүүлэх, зориудаар гаршуулан өсгөн үржүүлэх ажлыг зохион байгуулах, байгалийн популяцыг сэлбэн хамгаалах нь зөвхөн манай улс тедийгүй олон улсын ач холбогдолтойн зэрэгцээгээр гадаад орнуудаас эдийн засгийн дэмжлэг авах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь идлэг шонхорын нөөц хомстохоос урьдчилан сэргийлэх, түүний шалтгааныг арилгах, тоо толгойн хэвийн өсөлтийг хангахтай холбогдсон менежментийн ажлыг шинэчлэх, энэ талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлоход оршино.

2.2. Дээрх зорилгыг хангах үүднээс дор

дурдсан зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1. идлэг шонхорыг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах эдийн засгийн үндсийг бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.2.2. идлэг шонхорын экологи-биологийн судалгаа, мониторингийн ажлыг тогтмолжуулах замаар тархац, нөөц болон гадаадад гаргаж болох тоо хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийвчлан тогтоох, удмын санг хамгаалах, мэдээллийн санг бүрдүүлэх;

2.2.3. идлэг шонхорын хамгаалалтыг сайжруулахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх;

2.2.4. идлэг шонхорыг зориудаар гаршуулан өсгөн үржүүлж байгалийн популяцыг сэлбэх сүлжээг орон нутагт бий болгох;

2.2.5. идлэг шонхорыг хамгаалах, өсгөн үржүүлэх чиглэлээр үр дүнд хүрэхүйц олон улсын болон өөрийн орны төслүүдийг хэрэгжүүлэх.

**Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

Энэхүү хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр дор дурдсан арга хэмжээ авна:

3.1. Идлэг шонхорыг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах эдийн засгийн үндсийг бүрдүүлж, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

3.1.1. амьтны аймгийн тухай хуульд махчин шувуудын талаар нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж шийдвэрлүүлэх;

3.1.2. идлэг шонхорын үндсэн тархац нутгийг орон нутгийн болон улсын тусгай хамгаалалтад хамруулж, хамгаалалтын менежментийг сайжруулах;

3.1.3. идлэг шонхорыг барих, ашиглах журам, зааврыг боловсронгуй болгож мөрдүүлэх;

3.1.4. идлэг шонхорыг зөвшөөрөлгүй, хууль бусаар барих тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах;

3.1.5. идлэг шонхорыг хамгаалах ажлыг эрчимжүүлж, хууль бусаар барьсан талаар мэдээлсэн иргэдийг урамшуулах механизмыг бий болгох;

3.1.6. идлэг шонхорыг хамгаалахад олон улс, бүс нутгийн болон хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

3.1.7. идлэг шонхорын амьдрах орчин, тэдгээрийг хамгаалах ач холбогдлын талаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад анхан шатны мэдлэг олгох, иргэдэд идлэг шонхорын талаар сурталчлах, таниулах ажлыг эрчимжүүлэх;

3.1.8. идлэг шонхорыг хамгаалах чиглэлээр олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ тууштай биелүүлэх;

3.1.9. идлэг шонхорыг зориудаар гаршуулан өсгөн үржүүлэх үүрэг бүхий мэргэжлийн ферм, нэгжийг орон нутагт бий болгох, энэхүү санал санаачлагыг дэмжих эдийн засгийн орчинг бүрдүүлэх.

3.2. Идлэг шонхорын экологи-биологийн судалгаа, мониторингийн ажлыг тогтмолжуулах замаар тархац, нөөц болон гадаадад гаргаж болох тоо хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийвчлан тогтоох, удмын санг хамгаалах, мэдээллийн санг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1. идлэг шонхорын тархац, байршил, нөөц, нөхөн үржих онцлогийг судлан тогтоох, хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах загвар боловсруулж, энэ үндсэн дээр олон улсын жишигт нийцсэн шинжлэх ухааны арга, технологийг нэвтрүүлэх, биологи-экологийн цогц судалгааны төсөл хэрэгжүүлэх;

3.2.2. идлэг шонхорын биологи, генетик, экологийн судалгааны ажлын онол, арга зүйн түвшин, үр өгөөжийг дээшлүүлэх;

3.2.3. өндөр хөгжсөн зарим оронд идлэг шонхор судлаачдыг бэлтгэх, боловсон хүчнийг

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 21–ний өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

**"Мянганы зам" авто замын санхүүжилтийн тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Мянганы замын баруун чиглэлд Нарийн, Бөхөн шар, Доод-онгорхойн даваанууд болон Нурамтын хөтөлийн авто замын барилгын ажлын санхүүжилтийг баригдаж дууссаны дараа эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр тендер зарлан хэрэгжүүлэх, шаардлагатай санхүүжилтийг холбогдох хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах замаар шийдвэрлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 5 дугаар сарын 21–ний өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор баталсан "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт"-д доор дурдсан нэмэлт оруулсугай:

189.

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | Алтан домбо, аяга, таваг |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | YI-YП зуун /Түрэгийн үе/ |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний Түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | 1.сэнжтэй алтан аяга- 3х2.3см, 16.4 гр<br>2.цөгцөн суурьтай алтан аяга- 3.5х3см, 23.1 гр<br>3.алтан домбо-12.5х3.5см х 66.9гр<br>4.алтан таваг-6см, 14.9гр<br>5.алтан таваг-4.8см, 8.8гр |
| Дансны дугаар: | Y.2003-4-1 |

190.

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | Алтан ээмэг, алтан гогцоо, гинжин холбоотой алтан ээмэг |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | YI-YП зуун /Түрэгийн үе/ |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний Түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | 1.алтан ээмэг –сувд нь хагарсан, урт нь 4.5 см, 5.1 гр<br>2.алтан цагираг-3.9х3.2см, 34.4гр<br>3.гинжин холбоотой алтан ээмэг- урт 4 см, 8.7 гр |
| Дансны дугаар: | Y.2003-4-4 |

191.

| | |
|---|---|
| Дурсгалын нэр: | Бүсний алтан чимэглэлүүд |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | YI-YП зуун /Түрэгийн үе/ |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | Нэг бүсний янз бүрийн хэлбэртэй 18 ширхэг алтан чимэглэлүүд, 0.7 х 1 см – 3.5 х 2 см, нийт 71.8 гр |
| Дансны дугаар: | Y.2003-4-5 |

| | |
|---|---|
| 192. | |
| Дурсгалын нэр: | Алтан титэм |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | YI-YП зуун /Түрэгийн үе/ |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний Түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | Эрдэнийн чулуу амандаа зуусан шувууны толгой дүрсэлсэн алтан титэм, бусад шигтгээ нь унасан. 9.3 х 23 см, 80гр |
| Дансны дугаар: | Y.2003-4-46 |
| 193. | |
| Дурсгалын нэр: | Мөнгөн буга |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | YI-YП зуун /Түрэгийн үе/ |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний Түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | Эвэр болон хөл нь салж эвдэрсэн, хээ угалз, эврийг алтадсан, мөнгө16 х 12 см, 242 гр |
| Дансны дугаар: | Y.2003-4-43 |
| 194. | |
| Дурсгалын нэр: | Найман дэлбээт алтан чимэг |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | YI-YП зуун /Түрэгийн үе/ |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний Түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | Бүгд 48 ширхэг, 2 ширхэг нь гэмтэлтэй 5х5 см, нийт 124,7 гр |
| Дансны дугаар: | Y.2003-4-7 |
| 195. | |
| Дурсгалын нэр: | Аргалын толгойтой хүрэл сэлэм |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | МЭӨ 2000 он |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний Түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | Хүрэл, сэлэмний үзүүрийн хэсэг хугарч үгүй болсон 44.0х3.7х 1.5см |
| Дансны дугаар: | Y.84ц-2-1 |
| 196. | |
| Дурсгалын нэр: | Ямандаг |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | XIX зууны эцэс XX зууны эх |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний Түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | Алт шармал, хүрэл цутгуур 22.5х19.0х11.0 см |
| Дансны дугаар: | Y.64ц-1-59 |
| 197. | |
| Дурсгалын нэр: | Хантааз |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | XIX зууны эцэс XX зууны эхэн үе |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний Түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | Сувд, шүр, алтан саа даруулж хатгаж чимэглэсэн хүрэн пүүсүү, 65х62 см |
| Дансны дугаар: | Y.64-3-56 |
| 198. | |
| Дурсгалын нэр: | Хантааз |
| Зохиогч: | Нэр үл мэдэгдэх урчууд |
| Бүтээсэн он цаг: | XIX зууны эцэс XX зууны эхэн үе |
| Хаана хадгалагдаж буй: | Үндэсний Түүхийн музей |
| Дурсгалын шинж байдал: | Шүр, алтан сааг даруулан хатгаж чимэглэсэн шар торго, 61х62 см |
| Дансны дугаар: | Y.64-3-59 |

199.
Дурсгалын нэр: Хүрэм
Зохиогч: Нэр үл мэдэгдэх урчууд
Бүтээсэн он цаг: XIX зууны эцэс XX зууны эхэн үе
Хаана хадгалагдаж буй: Үндэсний Түүхийн музей
Дурсгалын шинж байдал: Шүр, алт саа хатгаж чимэглэсэн шар торгон хүрэм. 66x73x160см
Дансны дугаар: Ү.64-3-61

200.
Дурсгалын нэр: Эмээл, ташуур, нум сум, хоромсого сумын хамт, сэлэм хуйгийн хамт
Зохиогч: Нэр үл мэдэгдэх урчууд
Бүтээсэн он цаг: Дундад зууны үе
Хаана хадгалагдаж буй: Үндэсний Түүхийн музей
Дурсгалын шинж байдал: Нэг булшнаас олдсон иж бүрэн олдвор:1.арьсаар бүрсэн модон эмээл- 48x33x25см2.хус модон бариултай төмөр сэлэм, хусан хуйгийн хамт – 81 см3.үйсэн хоромсого, бургасан мөстэй, төмөр зэвтэй сумнууд 19 ш, урт нь 89.7 см4.бугын эвэр элэгтэй нум – 112 см5.бургасан ташуур – 53 см6.дөрөө -18x13.5см, 17x13.5см
Дансны дугаар: эмээл Ү.99х-9-3
сэлэм, хуй Ү.2001-8-9
хоромсого сумны хамт Ү.200-8-10
ташуур Ү.200-8-11
дөрөө Ү.2001-8-1.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 5 дугаар сарын 28–ны өдөр** **Дугаар 126** **Улаанбаатар хот**

**Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 1997 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн төрөл болон тэдгээрийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-д дор дурдсан нэмэлт оруулсугай:

| | | |
|---|---|---|
| 44 | Төрийн тусгай хамгаалалтын хүндэт тэмдэг | Тагнуулын ерөнхий газрын дарга |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 5 дугаар сарын 28–ны өдөр** **Дугаар 127** **Улаанбаатар хот**

**Өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай**

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Аймаг, нийслэлийн саналыг үндэслэн "Иргэдэд 2003 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалт"-ыг хавсралт ёсоор батлагсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

*Засгийн газрын 2003 оны 127 дугаар тогтоолын хавсралт*

## ИРГЭДЭД 2003 ОНД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН НИЙТ ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

| № | Аймгийн нэр | Өмчлүүлэх газрын байршил | Иргэдэд өмчлүүлэх газрын нийт хэмжээ /га-гаар/ | Одоо эзэмшиж, ашиглаж байгаа газрын нийт хэмжээ /га-гаар/ | Өмчлөх газрын зориулалт /га-гаар/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Гэр бүлийн хэрэгцээний | Аж ахуйн зориулалтаар | Газар тариалангийн | |
| | | | | | | | Тариалангийн талбай | Атаршсан газар |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Архангай | Аймгийн болон сумын төвд | 18209.7 | 18209.7 | 7441.4 | - | 2336.3 | 8432 |
| 2 | Баян-өлгий | Аймгийн болон сумын төвд | 2866 | 2866 | 1747 | 288 | 406 | 425 |
| 3 | Баянхонгор | Аймгийн болон сумын төвд | 571.7 | 391.7 | 571.7 | - | - | - |
| 4 | Булган | Аймгийн болон сумын төвд | 3933.78 | 3083.2 | 2992.68 | 941.1 | - | - |
| 5 | Говь-Алтай | Аймгийн болон сумын төвд | 5958.02 | 3616.92 | 2683.61 | 109.91 | 3164.5 | - |
| 6 | Говьсүмбэр | Аймгийн болон сумын төвд | 466.6 | 68.2 | 450.6 | 16 | - | - |
| 7 | Дархан-Уул | Аймгийн болон сумын төвд | 1962.95 | 1673.05 | 1633.54 | 329.41 | - | - |
| 8 | Дорноговь | Аймгийн болон сумын төвд | 2797.77 | 1109.77 | 2729.0 | 15.17 | 27.6 | 26 |
| 9 | Дорнод | Аймгийн болон сумын төвд | 20397.1 | 2698.2 | 20090.6 | - | 306.5 | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Дундговь | Аймгийн болон сумын төвд | 2355.2 | 2355.2 | 2355.2 | - | - | - |
| 11 | Завхан | Аймгийн болон сумын төвд | 615.4 | 615.4 | 351.6 | - | 263.8 | - |
| 12 | Орхон | Аймгийн болон сумын төвд | 6678.1 | 6678.1 | 636.6 | 58 | 5983.5 | - |
| 13 | Өвөрхангай | Аймгийн болон сумын төвд | 5924.7 | 3527.8 | 3173.80 | 2750.9 | - | - |
| 14 | Өмнөговь | Аймгийн болон сумын төвд | 4149.23 | 393.26 | 4029.43 | 20.5 | 99.3 | - |
| 15 | Сүхбаатар | Аймгийн болон сумын төвд | 741 | 741 | 741 | - | - | - |
| 16 | Сэлэнгэ | Аймгийн болон сумын төвд | 72082.38 | 69642.25 | 5322.07 | 3297.31 | 63443 | 20 |
| 17 | Төв | Аймгийн болон сумын төвд | 344402.2 | 248973.7 | 98778.2 | - | 245624 | - |
| 18 | Увс | Аймгийн болон сумын төвд | 1477.92 | 1477.92 | 1269 | 1.52 | 207.4 | - |
| 19 | Ховд | Аймгийн болон сумын төвд | 3974.4 | 2618 | 2207.54 | 5.1 | 1277.46 | 484.3 |
| 20 | Хөвсгөл | Аймгийн болон сумын төвд | 983.6 | 983.6 | 983.6 | - | - | - |
| 21 | Хэнтий | Аймгийн болон сумын төвд | 17573 | 17573 | 3151.4 | 21.6 | 14400 | - |
| 22 | Нийслэл | Нийслэлд | 4586.05 | 3315.05 | 4586.05 | - | - | - |
| | Нийт дүн | | 522706.8 | 392621.02 | 167925.62 | 7854.52 | 337539.36 | 9387.3 |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 2.5

☎ 329487